



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.15 № 02/20 УАГ-САГ/2013/25/СГА-ТТЗ

Улсын төсвийн орлого болгох тухай.

Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараахь зөрчил илэрлээ.

- Сангийн сайдын 2012 оны 295 тоот тушаалын дагуу байгууллагын мөнгөн хөрөнгийн буюу кассын үлдэгдэл 1499.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй,
- Цайны газрын түрээсийн орлого 8,6 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагналгүйгээр зарцуулсан,
- Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүйгээс Сартпланет ХХК-с 4917.0 мянга, Энжинекс ХХК-с 950.0 мянга, Санмит ком текс ХХК-с 110.0 мянга, Батзүү ХХК-с 2.1 сая төгрөг, нийт 8.1 сая төгрөгийн хөрөнгө болон бараа материал дутуу авсан ба эдгээр дутуу тооцоог авлага үүсгэж, тайлан тэнцэлд тусгаагүй зэрэг алдаа зөрчил гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, тайлагнах”, 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрийг санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, 19.1.4-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэснийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т “Төрийн өмчийн байр, эд хөрөнгийг ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

070059

1 Дээрх 18.2 сая төгрөгийг улсын төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 90000601 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Эдгээр зөрчлийг арилган биелэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын дарга Б. Пүрэвдорж, нягтлан бодогч Д.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав

АКТЫГ



ЗӨВШӨӨРСӨН:

